

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2024.07.26

Борхойн тал

<b>Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</b>		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 06 дугаар сарын 30	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117631	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж ТӨХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Энхболд	
<b>1.</b>	<b>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</b>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн	<b>1,184,773,484.14</b>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<b>4,580,017,161.48</b>
	Нийт хөрөнгийн дүн	<b>5,764,790,645.62</b>
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	<b>121,878,414.46</b>
	Өр төлбөрийн нийт дүн	<b>121,878,414.46</b>
	Эзэмшигчдийн өмчийн дүн	<b>5,642,912,231.15</b>
	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	<b>5,764,490,645.62</b>
Орлогын тайлан	Борлуулалтын орлого (цэвэр)	<b>1,455,741,577.66</b>

		Нийт ашиг (алдагдал)	1,455,741,577.66
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	121,103,083.65
		Татварын дараах ашиг (алдагдал)	107,562,085.75
		Нийт орлогын дүн	107,562,085.75
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч	4,620,000,000.13
		Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00
		Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00
		Хуримтлагдсан ашиг	94,054,151.02
		Нийт дүн	5,642,912,231.15
	Мөнгөн гүйлгээний тайлан	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
		Мөнгөн орлогын дүн (+)	1,619,771,649.21
		Мөнгөн зарлага (-)	1,358,945,968.19
		Цэвэр мөнгөн гүйлгээ	260,825,681.02
		<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
		Мөнгөн орлогын дүн (+)	28,047,906.52
		Мөнгөн зарлагын дүн (-)	91,113,392.52
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-63,065,486.00
		<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	197,760,195.02
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	769,277,198.99
2.	<b>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</b>		
	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний 07 тоот тогтоолоор тус зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Ж.Энхтулга, Х.Батхишиг, Б.Лхагвадорж нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тус хорооноос компанийн санхүүгийн тайланг жилд нэг удаа жилийн эцсээр хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээгүй болно.		
3.	<b>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</b>		

2024 оны эхний хагас жилийн байдлаар улсын хилээр орж ирж байгаа ачаа барааны эргэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад харьцангуй тогтвортой байсан боловч компанийн үйл ажиллагаагаар олж авч байгаа орлого буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 2455-аар их буюу 15,982 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн байна. Гэвч гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгслээс хураах хураамж өмнөх оныхоос буурсан нь 2023 онд хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл бүрийг гаалийн байгууллагын хүсэлтийн дагуу өөрийн автопүүн дээр пүүлж дээрх үйлчилгээг хийсний төлбөрийг давхар авдаг байсан нь тухайн жилийн тайланд нэмэгдсэн дүнтэй тусгагдсан учраас 2024 оны хадгалалт болон гарах хуудасны орлого буурсан дүнтэй харагдаж байгаа болно. Үүнээс гадна тээврийн хэрэгслээр орж ирж байгаа экспортын ачаа барааны гаалийн хяналт шалгалт бүрдүүлэлтийг тус компанийн гаалийн хяналтын бүсээр дамжуулан хийж гүйцэтгэж байгаа ба энэ үйлчилгээ өмнөх жилийнхээс мөн 257 тээврийн хэрэгслээр буурсан. Тус компанийн үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйлчилгээ нь мөн өмнөх оны мөн үеэс 272 вагоноор буурсан ба төмөр замын байгууллагаас компанийн салбар замд даац хэтрүүлсэн вагоны ачааг янзлуулах ажил мөн энэ жилээс хийгдээгүй гэх зэргээр шилжүүлэн ачилтаас олж байгаа орлого мөн тодорхой хэмжээгээр буурсан бөгөөд энэхүү тайланд тусгагдсан ачилтын орлого 251,250,924 төгрөгөөр өссөн гэж харагдаж байгааг хүснэгтийн доод хэсэгт тайлбарласан байгаа болно. Төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа одооны түвшингээс цаашид нэмэгдэхгүй гэж дүгнэж байгаа болно. Энэ байдал нь өмнөх жилүүдэд гарч байсан УБТЗ-ын монополь байдал, салбар замаар вагон тавьж олгохгүй байх явдлаас шалтгаалж үйлчлүүлэгч нар өөр шилжүүлэн ачих арга зам хайх, УБТЗ-д хандах зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж байдаг. Гэхдээ компанийн зүгээс орлого олох өөр арга замуудыг хайж Замын-Үүд сум дах гаалийн байгууллагатай хамтран компанийн өндөрлөсөн тавцанг ашиглан чингэлэг задлаж машин буулгах үйлчилгээг 5 сараар эхлүүлэн эхний хагас жилийн байдлаар 1052+ ш чингэлэг буулгаж задлаад байгаа бөгөөд энэ ажил нэлээн удаан үргэлжлэх боломжтой ажил юм. Үүнээс гадна тус компанийн офисст болон түрээсээр ажиллагсад, түүгээр үйлчлүүлэгчдийн ая тухтай ажиллах, үйлчлүүлэх нөхцөл бололцоог сайжруулах үүднээс офисс болон нэг цэгийн үйлчилгээний танхимын урсгал засварыг хийж ажилласан.

**3.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/**

Нийт ашгийн хувь: Үйл ажиллагаанд өртөг тооцдоггүй  
 Ахиуц цэвэр ашиг : 0,072%  
 Цэвэр ашгийн хувь: 8.1%  
 Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 2.1%  
 Эргэлтийн харьцаа: 9.72  
 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 6.65

**3.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт**

Хөрөнгийн байдлын үнэлгээ\		
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
	2024 оны хагас жил	
Хөрөнгийн ачаалал	0.32	1 төгрөг тутамд ногдох хөрөнгийн ашиглалтын байдал

	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	20.55	Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин өмнөх тайлант үеээс нэмэгдэж сайжирсан, үндсэн хөрөнгийн жин өндөр хэвээр.
	Элэгдлийн хувь	41%	Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь 41 хувь
<b>Санхүүгийн байдлын үнэлгээ</b>			
	<b>Төрөл</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Дүгнэлт</b>
		2024 оны хагас жил	
	Ажлын капитал	1,062,895,070	Ажлын капитал сайн ба эргэлтийн харьцаа 9.72 байгаа нь үйл ажиллагаанд богино хугацааны санхүүгийн дарамт байхгүйг илэрхийлж байна.
	Өрийн харьцаа	0.021	Нийт хөрөнгийн дотор зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хэсгийг илэрхийлнэ. 2-р улирлын байдлаар 0,021%-ийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.
	Эргэлтийн харьцаа	9.72	Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн.
	Бие даалтын коеф	0.97	Урт хугацаат өр төлбөргүй, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ бага байгаа нь компанийг өрийн дарамтгүй бие даан үйл ажиллагаа явуулах чадамж сайтайг илэрхийлж байна.
<b>3.3.</b>	<b>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</b>		

д/д	Орлогын нэр	2023 оны хагас жил	2024 оны хагас жил	Зөрүү
1	Ачилтын орлого	75,950,700	327,201,627	251,250,924
2	Хадгалалт болон гарах хуудас	1,187,170,137	856,700,755	-330,469,382
3	Түрээсийн орлого	23,325,000	30,575,758	7,250,758
4	Бусад орлого	334,283,754	271,843,403	-62,440,3251

Тайлбар: Төмөр замын ачаа тээврийн орлогын зөрүү 249,900,900 төгрөг нь Ачилтын орлогын бүртгэлийн зөрүүнээс үүсч байгаа зөрүү ба өмнө нь Ачилтын орлогыг Төмөр замд шилжүүлсэн тээврийн хөлсний зөрүүгээр бүртгэж байсан бол одоо нийт хүлээн авсан төлбөрийг тусгаж төмөр замд шилжүүлсэн тээврийн хөлсийг НӨАТ-ын 0 хувьтай дүнгээр бүртгэх болсон нь зөрүүтэй харагдаж байна.

3.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/

Байхгүй

4. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/

Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээжит хурлыг 2024 оны 04 сарын 30-ны өдөр " БиДиСек ҮЦК " ХК-ийн цахим хурлын системээр дамжуулан зохион байгуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн:

Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан  
 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах

Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах  
 ТУЗ-ийн 2024 оны цалин урамшууллын төсөв батлах  
 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох  
 Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинээр Б.Уранбайгаль, А.Бат-Орших нар ердийн гишүүнээр шинээр сонгогдон бусад гишүүд улиран сонгогдсон бөгөөд гишүүдийн хурлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр эчнээгээр зохион байгуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг шинэчилж томилсон. Тухайн гишүүдийг томилохдоо компанийн засаглалын кодексийг баримтлан хороодын даргыг хараат бус гишүүдээр томилсон болно. .

- 2023 оны жилийн санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд Их Монгол хөлөг аудит ХХК-иар аудит хийлгэн аудитын дүгнэлт тайлагналыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар аудитын компанийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

- Компанийн цахим хуудсыг шинэчлэн бэлэн болгосон. Компанийн засаглалын кодекс тогтоож өгсөн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам заавар, үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналууд зэрэг баримт бичгүүдийг хувьцаа эзэмшигчидэд шууд үзэх болон татаж авах байдлаар хийж байршуулсан. Цаашид цахим хуудас болон сошиал хуудаснуудын байнгын ажиллагааг хангаж ажиллахад анхаарч ажиллаж байна.

- Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналуудыг хууль журмаар тогтоосон хугацаанд нь гарган Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллаж байгаа ба Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тайлагналуудыг тогтмол байршуулж байна.

- Компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэх заавар, журмуудыг шинээр үлгэрчилсэн журам зааврыг баримтлан боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж үнэлэлт дүгнэлт өгүүлж ажилласан.

**7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл**

Засаглалын үнэлгээний тайланг холбогдох журам зааварт заасныг баримтлан гаргаж хүргүүлсэн.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Чулуун Энхболд

Албан тушаал: "Э-Транс Логистикс" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)



Овог, нэр: .....

Албан тушаал: "Их Монгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн  
этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Содномцэрэн Ганбат

Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан

Гарын үсэг: *Содномцэрэн Ганбат*